



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/161

Мандалговь

Буцалтгүй тусламж үзүүлж, эмгэнэл  
илэрхийлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “г”, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын харьяат Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн Жаалын Пүрэв, Ардын Их хурлын депутат, 1996-1998 онд аймгийн Засаг даргын орлогчоор ажиллаж байсан Мятавын Моёор нар таалал төгссөн явдалд гүн эмгэнэл илэрхийлж, буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

Хоёр. Буцалтгүй тусламжид тус бүр 500000 (таван зуун мянга) төгрөг, нийт 1000000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРА



О.БАТ-ЭРДЭНЭ

438190451